



**НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 01/21

Улаанбаатар хот

Илүү цагийн нэмэгдэл
хөлс олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2022 оны 490 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/402 дугаар захирамж, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийг 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулахад ажилласан албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосугай.

2. Албан хаагчдад олгох илүү цагийн нэмэгдэл хөлсийг зохих журмын дагуу тооцож олгохыг Нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Цогзолмаа)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2025 оны 06 дугаар сарын 04-ны
өдрийн 21 дугаар тушаалын хавсралт



2025 ОНЫ 06 ДУГААР САРД
ИЛҮҮ ЦАГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ
АЛБАН ХААГЧДЫН НЭРС

№	Албан тушаалын нэр	Нэр	Илүү цаг
1.	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга	М.Цогзолмаа	16
2.	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн	Г.Бямбасайхан	16
3.	Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн Ахлах мэргэжилтэн	Э.Мөнх-Эрдэнэ	16
4.	Хэвлэл мэдээлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	Н.Өлзийжаргал	16
5.	Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн	А.Амарзаяа	16
6.	Спортын тэмцээн наадам, спортын холбоод хариуцсан мэргэжилтэн	С.Хархад	16
7.	Архив, бичиг хэргийн эрхлэгч	У.Буян-Орших	16
8.	Нягтлан бодогч	С.Ганчимэг	16
9.	Төрийн болон аж ахуйн нэгж байгууллага дахь биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн	Ө.Мягмаржав	16